

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ
2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	2
1.1. ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ.....	2
1.2. ХӨРВӨХ ЧАДВАР	3
1.3. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКСҮҮД	3
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ	4
2.1. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙЛҮҮЛЭЛТ	4
2.1.1. Хувьцааны арилжаа.....	4
2.1.2. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа	2
2.1.3. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа.....	2
2.1.4. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа	1
2.1.5. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа.....	8
2.2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ	8
2.2.1. Хөрөнгө оруулагчдын бүтэц	8
2.3. БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	1
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД	1
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ	2


НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Олон улсын валютын сан, Дэлхийн банкнаас хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хөгжлийн түвшнийг үнэлж, тогтоох хүрээнд хөрөнгийн зах зээлийн хөгжлийн голлох үзүүлэлтүүд болох дараах индикаторуудыг оруулсан байдаг: зах зээлийн үнэлгээ, зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувь, хөрвөх чадвар, хувьцааны индекс.

1.1. ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2023 оны 2 дугаар улирлын байдлаар 10.99 их наяд төгрөг болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 127.2 хувиар өссөн бөгөөд уг үзүүлэлт ДНБ-ний 20.8 хувьтай тэнцэж байна.

График 1. ДНБ-д харьцуулсан хөрөнгийн зах зээлийн үнэлгээ



Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээг бүрдүүлж байгаа үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нийт 187 компаниас 30 компанийн зах зээлийн үнэлгээ хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээний 94.92 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 1. Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 30 компани


№	Компанийн нэр	Эзлэх хувь	№	Компанийн нэр	Эзлэх хувь
1	"ХААН банк" ХК	19.47%	16	"Ард санхүүгийн нэгдэл" ХК	0.89%
2	"Худалдаа хөгжлийн банк" ХК	15.64%	17	"Улсын Их Дэлгүүр" ХК	0.88%
3	"АПУ" ХК	12.34%	18	"Монгол Шуудан" ХК	0.83%
4	"Голомт банк" ХК	6.69%	19	"Гутал" ХК	0.79%
5	"Хас банк" ХК	6.12%	20	"Тэнгэрлиг медиа групп" ХК	0.65%
6	"Таван Толгой" ХК	5.37%	21	"Түмэн шувуут" ХК	0.61%
7	"Инвескор ББСБ" ХК	3.93%	22	"Газар шим үйлдвэр" ХК	0.56%
8	"Төрийн банк" ХК	3.69%	23	"УБ-БҮК" ХК	0.47%
9	"МИК Холдинг" ХК	3.31%	24	"Монголын хөрөнгийн бирж" ХК	0.46%
10	"Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн" ХК	2.82%	25	"Монос Хүнс" ХК	0.39%
11	"Говь" ХК	2.09%	26	"Мандал Даатгал" ХК	0.38%
12	"Монгол Даатгал" ХК	1.78%	27	"Сэндли ББСБ" ХК	0.35%
13	"Сентрал экспресс Си Ви Эс" ХК	1.24%	28	Мандал Ирээдүйн Өсөлт	0.34%
14	"Сүү" ХК	1.22%	29	"Ард Кредит ББСБ" ХК	0.34%
15	"Богд Банк" ХК	1.00%	30	"Талх Чихэр" ХК	0.28%

Тайлбар: Зах зээлийн үнэлгээнд 100 хувь төрийн өмчит компанийн үнэлгээ ордоггүй болно.

1.2. ХӨРВӨХ ЧАДВАР

Тайлант хугацаанд хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.4 пунктээр буурч, 0.95 хувьд хүрсэн байна. Манай улсын хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар бага байгаа нь хувьцааны хэт төвлөрөлтэй холбоотой юм. Тухайлбал 2023 оны 2 дугаар улирлын байдлаар ТОП-20 индексэд багтах ХК-уудын хувьцааны төвлөрлийг тооцож үзэхэд хэт төвлөрөлтэй буюу нийт хувьцааны 77.36 хувийг 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна.

График 2. Хөрвөх чадвар (хувиар)



1.3. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКСҮҮД

“Монголын хөрөнгийн бирж” ХК-аас ТОП-20, MSE-A, MSE-B гэсэн гурван төрлийн хувьцааны үнийн индексүүдийг тооцон гаргадаг. ТОП-20 индексээр зах зээлийн үнэлгээ болон хувьцаа нь идэвхтэй арилжаалагддаг нэр бүхий 20 компанийн, MSE-A болон MSE-B индексээр үнэт цаасны бүртгэлийн I, II ангилалд багтсан компаниудын хувьцааны үнийн индексийг тус тус харуулдаг байна.

Хүснэгт 2. Индексийн үзүүлэлт

Индекс	2022.ИИ	2023.ИИ	Өөрчлөлт
ТОП 20	32,795.68	36 899.16	+12.51%
MSE A	12,384.65	16 216.23	+30.94%
MSE B	11,450.93	12 178.61	+6.35%

Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

ТОП-20 индексийн дээд үзүүлэлт тайлант хугацааны байдлаар 40,386.51 нэгж, доод үзүүлэлт 35,154.41 нэгж, дундаж үзүүлэлт 37,315.18 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4,103.48 нэгжээр буюу 12.51 хувиар өсөж, **36,899.16** нэгж болсон байна.

MSE-A индексийн дээд үзүүлэлт тайлант хугацааны байдлаар 19,652.35 нэгж, доод үзүүлэлт 14,088.84 нэгж, дундаж үзүүлэлт 16,138.53 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3,831.58 нэгжээр буюу 30.94 хувиар өсөж, **16,216.23** нэгж болсон байна.

Харин MSE-B индексийн дээд үзүүлэлт 12,917.95 нэгж, доод үзүүлэлт 11,920.21 нэгж, дундаж үзүүлэлт 12,481.94 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 727.68 нэгжээр буюу 6.35 хувиар өсөж, **12,178.61** нэгж болсон байна.


ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ

2.1. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙЛҮҮЛЭЛТ

2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 533.94 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа хийгдсэнээс 512.86 тэрбум төгрөгийн арилжаа арилжаа эрхлэх байгууллагаар, 21.08 тэрбум төгрөгийн арилжаа хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сангаар дамжуулан хийгдсэн байна.

Тайлант хугацаанд хувьцааны арилжаа түлхүү явагдсан бөгөөд нийт үнэт цаасны арилжааны 80.5 хувийг хувьцаа, 7.9 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, 7.01 хувийг компанийн өрийн хэрэгсэл, 4.59 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа тус тус эзэлж байгаа бөгөөд нийт үнэт цаасны арилжааны хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.94 дахин өссөн үзүүлэлттэй байна.

График 3. Үнэт цаасны арилжааны хэмжээ (бүтээгдэхүүний төрөл, хувиар)



Харин Хөдөө аж ахуйн биржээр тайлант хугацаанд 109 удаагийн цахим арилжаа зохион байгуулагдсан ба нийт 494.9 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан байна.

2.1.1. Хувьцааны арилжаа

График 4. Хувьцааны арилжаа (тэрбум төгрөгөөр)

Тайлант хугацаанд нийт 429.8 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.78 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Үүнээс хувьцааны анхдагч зах зээлд нийт 324.96 тэрбум төгрөгийн, хоёрдогч зах зээлд нийт 104.84 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа тус тус хийгдсэн байна.



Хоёрдогч зах зээл дээрх хувьцааны арилжааг арилжаа эрхлэх байгууллага дээр бүртгэлтэй нийт компаниас арилжааны хэмжээгээрээ тэргүүлэгч 30 компанийн арилжааны мэдээллийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3. Арилжааны хэмжээ хамгийн өндөр 30 компанийн арилжааны үнийн дүн (тэрбум төгрөгөөр)

№	Компанийн нэр	Арилжааны үнийн дүн	№	Компанийн нэр	Арилжааны үнийн дүн
1	“Инвескор ББСБ” ХК	13.7	16	“Ард Даатгал” ХК	1.35
2	“Худалдаа хөгжлийн Банк” ХК	12.7	17	“Төрийн Банк” ХК	1.12
3	“ХААН Банк” ХК	12.46	18	“Түмэн шувуут” ХК	1.0
4	“Голомт Банк” ХК	9.8	19	“Монос Хүнс” ХК	0.99
5	“АПУ” ХК	6.7	20	“Ард Кредит ББСБ” ХК	0.94
6	“Монголын хөрөнгийн бирж” ХК	5.6	21	“Газар шим үйлдвэр” ХК	0.72
7	“Ард санхүүгийн нэгдэл” ХК	5.28	22	“Монгол Шуудан” ХК	0.66
8	“Богд Банк” ХК	5.08	23	“Бодь Даатгал” ХК	0.54
9	“Атар-Өргөө” ХК	4.0	24	“Хорин хоёрдугаар бааз” ХК	0.53
10	“Говь” ХК	3.78	25	“Мандал Даатгал” ХК	0.47
11	“Сентрал экспресс Си Ви Эс” ХК	3.68	26	“Тэнгэрлиг медиа групп” ХК	0.43
12	“Таван Толгой” ХК	2.36	27	“ЛэндМН ББСБ” ХК	0.41
13	“Монбиф” ХК	2.34	28	“Крипто Үндэстэн” ХК	0.4
14	“Талх Чихэр” ХК	2.18	29	“Монгол Базальт” ХК	0.4
15	“Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” ХК “Говь” ХК	1.88	30	“Сэндли ББСБ” ХК	0.35
НИЙТ					101.96

2.1.1.1. Багцын арилжаа

Тайлант хугацаанд нийт 15 хувьцаат компанийн 50.6 сая ширхэг буюу 40.36 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий багцын арилжаа хийгдсэн нь нийт хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны 38.5 хувийг эзэлж байна.

Хүснэгт 4. Багцын арилжаа хийгдсэн компаниуд

№	ҮНЭТ ЦААСНЫ НЭР	Арилжсан ширхэг	Үнийн дүн
1.	“Инвескор ББСБ” ХК	2,180,510.00	11,748,612,650.00
2.	“Худалдаа Хөгжлийн Банк” ХК	357,823.00	10,843,229,680.00
3.	“Голомт Банк” ХК	3,175,655.00	4,074,829,507.00
4.	“Говь” ХК	7,500,000.00	2,625,000,000.00
5.	“АПУ” ХК	2,135,393.00	2,508,358,585.00
6.	“Богд банк” ХК	18,525,879.00	2,256,106,455.00
7.	“Сентрал экспресс Си Ви Эс” ХК	8,413,462.00	1,986,190,017.00
8.	“ХААН Банк” ХК	1,000,000.00	1,150,000,000.00
9.	“Ард санхүүгийн нэгдэл” ХК	321,712.00	1,028,851,830.00
10.	“Ард Даатгал” ХК	933,763.00	853,544,600.00
11.	“Бодь Даатгал” ХК	4,033,583.00	500,164,292.00
12.	“Хорин хоёрдугаар бааз” ХК	213,419.00	499,827,298.00
13.	“Монголын хөрөнгийн бирж” ХК	1,691,342.00	253,701,300.00
14.	“Мандал говь импекс” ХК	52,612.00	32,730,428.00
15.	“Өлзий-Дундговь” ХК	73,828.00	7,382,800.00
ДҮН		50,608,981.00	40,368,529,442.00

Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

2.1.2. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа

График 5. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа (тэрбум төгрөгөөр)

Тайлант хугацаанд компанийн өрийн хэрэгслийн нийт арилжаа 37.45 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.7 дахин буурсан үзүүлэлт юм.

Компанийн өрийн хэрэгслийн анхдагч зах зээлд нийт 26.5 тэрбум төгрөг, хоёрдогч зах зээлд нийт 10.95 тэрбум төгрөгийн арилжаа тус тус хийгдсэн байна.



Хороо тайлант хугацаанд 4 компанийн гаргаж буй өрийн хэрэгслийг бүртгэсэн. Үүнд:

- “Сэндли ББСБ” ХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 85,000 ширхэг өрийн хэрэгслийг бүртгэсэн.
- “Бизнес-Инвест девелопмент ББСБ” ХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 80,000 ширхэг өрийн хэрэгслийг бүртгэсэн.
- “ХААН банк” ХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 170,000 хүртэл ширхэг, нэг бүр нь 100 ам.долларын нэрлэсэн үнэ бүхий 250,000 хүртэл ширхэг өрийн хэрэгслийг бүртгэсэн.
- “Ашид капитал ББСБ” ХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 200,000 ширхэг өрийн хэрэгслийг бүртгэсэн.


2.1.3. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль батлагдсанаас хойш 2023 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 38 компани хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байна.

Тайлант хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооноос 1 компанид хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгож, 1 компанийн хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэсэн байна. Үүнд:

- “Ашид ассет менежмент ҮЦК” ХХК-ийн үүсгэн байгуулсан “Ашид арвижих” хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сан нэгж эрхийн анхдагч зах зээлд арилжих ажиллагааг амжилттай зохион байгуулж, 10,121,444 ширхэг нэгж эрхийг нэг бүрийг 100 (нэг зуун) төгрөгөөр олон нийтэд санал болгон арилжаалж, нийт 1,012,144,400 төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.
- “Инвескор ассет менежмент ҮЦК” ХХК-ийн үүсгэн байгуулж буй “Инвескор Глобал Кью” хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэсэн.

График 6. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа (тэрбум төгрөгөөр)



Тайлант хугацаанд хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн анхдагч зах зээлд нийт 1.01 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн бол хоёрдогч зах зээлд нийт 23.48 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж нийт 24.49 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна.

График 7. Тайлант хугацаанд хийгдсэн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжааны задаргаа (тэрбум төгрөгөөр)

Тайлант хугацаанд хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлд нийт 23.48 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэнээс хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангаар 3.4 тэрбум төгрөгийн арилжаа, хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сангаар 20.08 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь тус тус нийт арилжааны 14 болон 86 хувийг бүрдүүлж байна.




2.1.4. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа

Тайлант хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооноос 6 компанид хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосноос 4 компанийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэсэн байна. Үүнд:

- 2023 оны 256, 257 дугаар тогтоолоор тус тус "Омни ассет" ХХК, "ҮЦСК актив зургаа" ХХК-д тус тус хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бол 88, 151, 181, 209 дүгээр тогтоолоор тус тус "Бэрс Эй Би Эс плас ТЗК" ХХК, "ҮЦСК Актив тав ТЗК" ХХК, "Бичил Эй Би Эс плас ТЗК" ХХК, "МИК актив гучин гурав ТЗК" ХХК-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэсэн байна.

График 8. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа (тэрбум төгрөгөөр)



Тайлант хугацаанд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаагаар 29 тэрбум төгрөгийн арилжаа, хоёрдогч зах зээлд нийт 13.2 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж, нийт 42.2 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна.

2.1.5. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа

Тайлант хугацаанд Хөдөө аж ахуйн бирж нь 109 удаагийн цахим арилжаа зохион байгуулан 773 хэлцлээр нийт 494.9 тэрбум төгрөгийн үнэ бүхий бараа, түүхий эдийн арилжаа хийсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 227.2 тэрбум төгрөгөөр буюу 31.0 хувиар буурсан үзүүлэлт бөгөөд дараах төрлийн бүтээгдэхүүнүүд арилжаалагдсан байна. Үүнд:

Зураг 1. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа



Хүснэгт 5. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны дүн (бүтээгдэхүүний төрлөөр)


Ямааны ноолуур	419,742,799,000.00	Нийт арилжааны дийлэнх хувийг буюу 84.81 хувийг ямааны ноолуур, 9.36 хувийг завод ноос, 4.01 хувийг тосны ургамал, 1.33 хувийг хонины ноос, 0.48 хувийг тэмээний ноос тус тус эзэлж байгаа бол үлдсэн хэсэг болох 0.01 хувийг бодын хөөвөр болон арьс шир бүрдүүлж байна.
Хонины ноос	6,569,835,000.00	
Завод ноос	46,314,449,000.00	
Тэмээний ноос	2,381,090,000.00	
Тосны ургамал (рапс)	19,843,900,000.00	
Бодын хөөвөр	47,300,000.00	
Арьс шир	6,600,000.00	
Нийт	494,905,973,000.00	

2.2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ

Тайлант хугацаанд **106,267** шинэ данс, **45,169** холболтын данс шинээр нээгдэж өссөн дүнгээр нийт **2,552,557** данс, **613,070** холболтын данс “ҮЦТХТ” ХХК-д бүртгэлтэй байна.

2.2.1. Хөрөнгө оруулагчдын бүтэц

График 9. Гадаад дотоодын хөрөнгө оруулагчдын арилжааны үнийн дүнд эзлэх хувь



Тайлант хугацаанд нийт арилжаанд дотоодын иргэний хийсэн арилжаа 74.8 тэрбум төгрөг (56.3 хувь), дотоодын аж ахуйн нэгжийн хийсэн арилжаа 55.0 тэрбум төгрөг (41.4 хувь), гадаадын иргэний хийсэн арилжаа 1.25 тэрбум төгрөг (0.94 хувь), гадаадын аж ахуйн нэгжийн хийсэн арилжаа 1.8 тэрбум төгрөг (1.37 хувь)-ийг тус тус эзэлж нийт 132.84 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна.

2.3. БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Биржийн бус зах зээлийн зохицуулалтыг орчныг тодорхой болгохоор “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-ыг баталсан. Биржийн бус зах зээл нь биржийн зах зээлтэй харьцуулахад мэргэжлийн хөрөнгө оруулагчид оролцдог онцлогтой бөгөөд энэ нь үнэт цаас гаргах гэж буй компаниудад тавигдах шалгуур нь харьцангуй бага байх, үнэт цаас гаргах цаг хугацаа, зардал хэмнэх зэрэг олон давуу талыг олгож байна.

Биржийн бус зах зээлийн үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс 2023 оны 2 дугаар улирал хүртэлх хугацаанд биржийн бус зах зээлд нийт 82 компанийн нийт 2.1 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий 108 өрийн хэрэгсэл гарсан бөгөөд 1.47 их наяд төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн байна. Үүнээс тайлант хугацаанд 29 үнэт цаас гаргагчийн 677.2 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий, 85 транч өрийн хэрэгслийг бүртгэж, 474.6 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

График 10. Тайлант хугацаанд ББЗЗ-д бүртгэгдсэн нийт өрийн хэрэгслийг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны салбараар ангилсан тоон мэдээлэл (хувиар)

Тайлант хугацаанд бүртгэгдсэн нийт өрийн хэрэгслийн татан төвлөрүүлэхээр зарласан дүнг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны салбараар нь ангилбал уул уурхай 34.0 хувь, банк бус 24.0 хувь, үл хөдлөх 10.0 хувь, санхүү 29.0 хувь, бусад салбар 3.0 хувийг бүрдүүлж байна.




График 11. Тайлант хугацаанд ББЗЗ-д бүртгэгдсэн нийт өрийн хэрэгслийг Бондын хүүгийн түвшин, хүүгийн хугацаа (хувиар)



Тайлант хугацаанд бүртгүүлсэн өрийн хэрэгслийн хүү өрийн хэрэгслийн хугацаанаас хамааран 10.0 хувиас 20.3 хувь хүртэл байгаа бөгөөд 12 сараас 48 сарын хугацаатай байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД

Өнөөдрийн байдлаар үнэт цаасны зах зээл дээр Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Инновацийн тухай хууль зэрэг хуулиуд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Эдгээр хууль болон бусад холбогдох

дүрэм, журам, зааврын хэрэгжилтэд хяналт тавих, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиг үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлж байна.

Дээрх хууль тогтоомжийн хүрээнд тайлант хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл болон бүртгүүлсний үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж буй 287 зохицуулалттай этгээд байна.

Хүснэгт 6. Үнэт цаасны зах зээлд оролцогчид

№	Үйл ажиллагааны төрөл	Тоо
Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэгч		
1	Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага	3
2	Үнэт цаасны тооцооны байгууллага	2 ¹
3	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага	1
4	Үнэт цаасны төлбөрийн байгууллага	1 ²
5	Хөрөнгө оруулалтын менежментийн компани	38
6	Хамтын хөрөнгө оруулалтын сан /хаалттай, нээлттэй/	5
7	Кастодиан банк	3
8	Үнэт цаасны компани	52
	Брокер	51
	Үүнээс:	
	Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа эрхлэгч	14
	Номинал дансаар дамжуулан харилцагчдад мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээний үйлчилгээний үйлчилгээ үзүүлэгч	15
	Дилер	33
	Андеррайтер	22 ³
	Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлэгч	19
9	Хөрөнгө итгэмжлэн удирдагч	8
10	Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч	1
11	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөлтэй компани	55 ⁴
12	ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн биржийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага	1
13	ХАА-н биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага	10
14	Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага	1*
15	Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох байгууллага	1
Бүртгэлтэй хөндлөнгийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд		
16	ҮЦЗЗ-д оролцогчид аудитын үйлчилгээ, хөрөнгийн үнэлгээ үзүүлэгч байгууллага	66 ⁵
	Аудитын үйлчилгээ үзүүлэгч байгууллага	48
	Хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэгч байгууллага	24
17	ҮЦЗЗ-д оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэгч байгууллага	40
Нийт (ТЗ болон бүртгүүлсний үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж буй компаниудын тоо)		287

¹ Тус тоонд үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага болох “Улаанбаатар Үнэт Цаасны Бирж” ХК болон “МУЦКТ” ХХК орсон болно.

² “ҮЦТХТ” ХХК нь үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн болон төлбөрийн үйл ажиллагааг үзүүлдэг.

³ Тус тоонд андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 2 банк /“Голомт банк” ХК, “Тээвэр Хөгжлийн банк” ХХК/ орсон болно.

⁴ Тус тоонд “МИК ОССК” ХХК-33, “ҮЦСК” ХХК-6, “Носк тав ТЗК” ХХК-5, нээлттэй хүрээнд ХБУЦ гаргасан 10 ТЗК, хаалттай хүрээнд гаргасан 1 ТЗК тус тус орсон.

⁵ ҮЦЗЗ-д оролцогчид аудитын үйлчилгээ, хөрөнгийн үнэлгээ үзүүлэх үйлчилгээг зэрэг үзүүлдэг 6 компани байна.

Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нийт 187 ХК байна. Мөн Хорооны 2015 оны 06-р сарын 10-ны өдрийн 273 дугаар тогтоолоор “Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо” ГҮТББ-ыг, 2015 оны 10-р сарын 13-ны өдрийн 379 дүгээр тогтоолоор “Монголын Хөрөнгийн Бирж” ХК-ийг өөрийгөө зохицуулах байгууллагаар тус тус бүртгэсэн.

Хүснэгт 7. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй ХК-ийн тоо болон зах зээлийн үнэлгээ

	Бүртгэлтэй ХК-ийн тоо	Зах зээлийн үнэлгээ 2023.II
1) “Монголын Хөрөнгийн Бирж” ХК <i>-100 хувь төрийн өмчит</i> <i>-Төрийн өмчийн оролцоотой</i> <i>-Төрийн өмчийн оролцоогүй</i>	186 16 11 159	10,996,506,058,262.00 ₮ <i>(Тус биржийн зах зээлийн үнэлгээнд 100 хувь төрийн өмчит компанийн үнэлгээ ордоггүй болно.)</i>
2) “Улаанбаатар Үнэт Цаасны Бирж” ХК	1	2,107,910,466 ₮
3) “Чингис хаан хөрөнгийн бирж” ХХК	-	-

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооноос 2023 оны эхний хагас жилийн байдлаар Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх чиглэлд голчлон анхаарч дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

4.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль

Монгол Улсын Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр 52 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Хөрөнгийн зах зээлийн холбогдох хууль эрх зүйн орчин шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэг бүхий” ажлын хэсгийн зүгээс Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж, Сангийн сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулсан. Түүнчлэн уг ажлын хэсгийн зүгээс Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл болон тус хуулийг дагалдан өргөн баригдах Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Компанийн тухай хууль, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцэслэн боловсруулж, улмаар Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, зөвшөөрөл авсны үндсэн дээр 2023 оны Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганд өргөн мэдүүлэхээр ажиллаж байна.

4.2. Банкны салбарын реформ:

Банкны салбарын реформын хүрээнд банкны системд нөлөө бүхий банкнуудын нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргах ажиллагааг амжилттай хэрэгжүүлж, нээлттэй хувьцаат компани хэлбэртэй болох хуулийн шаардлагыг хангуулах хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс зохицуулалтын орчныг боловсронгуй болгож, олон улсын жишигт нийцүүлэхийн зэрэгцээ нийтэд санал болгон үнэт цаас гаргахтай холбогдуулан зөвлөгөө мэдээлэл өгөх, зохицуулалтын бодлогоор тухай бүр дэмжлэг үзүүлэн ажиллалаа.

Банкны системд нөлөө бүхий банкнуудаас “Төрийн банк” ХК, “Голомт банк” ХК, “ХААН банк” ХК, “Худалдаа Хөгжлийн банк” ХХК, “Хас банк” ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасыг Хорооны 2022 оны 505, 634, 689, 2023 оны 179, 180 дугаар тогтоолоор тус тус бүртгэсэн. Үүний дагуу банкны системд нөлөө бүхий банкнууд болох

дээрх 5 банкны IPO хийх ажиллагаа амжилттай хэрэгжиж нийт 446.79 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Банкны реформ нь арилжааны банкнуудад зохистой засаглалыг бий болгох, олон нийтийн хяналттай, нээлттэй, ил тод банкны салбарыг бүрдүүлэхэд томоохон түлхэц болж буй төдийгүй зөвхөн банкны салбар бус, нийт санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, нэн ялангуяа хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой шийдвэр болсон.

4.3 Хамтын ажиллагаа

Санхүүгийн зохицуулах хороо Олон улсын санхүүгийн корпораци болон Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимтай хамтран 2023 оны 3 дугаар сарын 13-ны өдөр “Санхүүжилт татах боломж, тогтвортой санхүү болон ногоон бонд” хэлэлцүүлэг уулзалтыг зохион байгуулж ТОП-100 аж ахуйн нэгжүүдэд тогтвортой санхүүжилт, ногоон бондын ач холбогдол, энэ талаарх мэдлэгийг дээшлүүлэх, тэдгээрийн зохицуулалтын орчны талаар мэдээлэл өгсөн.

Түүнчлэн ТОП-100 аж ахуйн нэгжүүдийг хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор Санхүүгийн зохицуулах хороо МҮХАҮТ-тай хамтран “ТОП-100 аж ахуйн нэгжийн хөрөнгийн зах зээл дэх оролцоог өсгөх арга хэмжээний хөтөлбөр”-ийг 2023 оны 5 дугаар сарын 22-ны өдөр баталсан.

4.4. Төрийн өмчит компаниудын хувьчлал

Улсын Их Хурлын 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 16 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлийг баталсан. Үүнтэй холбогдуулан Засгийн газраас 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар 2022-2023 онд биржээр төрийн мэдлийн 34 хувийн хувьцааг нээлттэй худалдах, олон нийтийн хяналтад шилжүүлэх төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалтыг баталсан.

Үүний дагуу тайлант хугацаанд “Үндэсний давхар даатгал” ХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 87 дугаар тогтоолоор бүртгэсэн.

Нэр бүхий төрийн өмчит хувьцаат компаниудыг хөрөнгийн биржээр дамжуулан хувьчлах ажиллагааг амжилттай хэрэгжүүлснээр компанийн засаглал, мэдээллийн ил тод байдал сайжирч, олон улсын жишгийн дагуу мэргэжлийн хөрөнгө оруулагчид удирдлагын багийг хэрэгжүүлж үйл ажиллагааны ашиг орлогыг нэмэгдүүлэх, улмаар гадаадын хөрөнгө оруулагчдыг татах чухал ач холбогдолтой юм.

4.5. Уул уурхайн бүтээгдэхүүний бирж

Улсын Их Хурлаас уул уурхайн бүтээгдэхүүний үнийг шударгаар тогтоох, борлуулалтыг нээлттэй, зах зээлийн зарчимд нийцсэн байдлаар хийх зэрэг уул уурхайн бүтээгдэхүүний экспортын арилжааг ил тод, нээлттэй болгох зорилгоор Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг баталсантай холбогдуулан нүүрсний цахим арилжааг хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх хүртэлх хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-аар дамжуулан хийхийг Засгийн газарт, цахим арилжаанд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хороонд даалгасан. Түүнчлэн “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2-т заасныг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн

газрын 2022 оны 466 дугаар тогтоолоор нүүрс экспортлогч аж ахуйн нэгжийн экспортод гаргах нүүрсийг цахимаар нээлттэй арилжих үйл ажиллагааг зохион байгуулах, түүнтэй холбогдон үүсэх бусад харилцааг зохицуулсан "Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам"-ыг баталсан билээ. Уг журмын хэрэгжилтэд Санхүүгийн зохицуулах хороо хяналт тавихаар зохицуулсны дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос "Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжаанд тавих хяналтын журам"-ыг 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамтай хамтран баталж, экспортод гаргах нүүрсний цахим арилжаанд хяналт тавин ажилласан.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг баталсантай холбогдуулан уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа, төлбөр тооцооны бэлэн байдлыг хангаж, тус хуульд заасан журмын төслүүдийг хамтран боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны даргын тушаалаар байгуулсан бөгөөд уг ажлын хэсгийн зүгээс хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллахтай холбоотой бэлтгэл ажлуудыг хийж гүйцэтгэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, дүрэм, журам боловсруулах зэрэг шаардлагатай арга хэмжээг авч ажиллаа.

Тухайлбал Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.3, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-г тус тус заасан холбогдох журмуудыг Хороо батлахаар заасан. Үүний дагуу журмын төслүүдийг эцэслэн боловсруулж, Хорооны хуралдаанаар хэлэлцүүлж 2023 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн Хорооны 186, 187, 189 дүгээр тогтоолоор тус тус "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн болон биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам", "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа төлбөр, тооцоо хийх ерөнхий журам", "Үүсмэл санхүүгийн хэрэгсэл гаргагчид тавих нөхцөл, шаардлага, шалгуур болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт, түүнийг арилжих журам" -ын төслүүдийг баталсан. Мөн 2023 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн Хорооны 318, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны А/231 дугаар хамтарсан тушаалын дагуу "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны болон ханшийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, ашиглах, мэдээллийг нийтэд хүргэх журам"-ыг баталсан.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд зааснаар бирж нь төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд байх мөн биржийн арилжааг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх бол Засгийн газар шийдвэрлэхээр хуульчилсны дагуу Засгийн газраас 2023 оны хоёрдугаар сард уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааг "Монголын хөрөнгийн бирж" ХК-аар гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн. Харин Хорооны 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар "Монголын хөрөнгийн бирж" ХК-д уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон. Ийнхүү Монгол Улсад анхны уул уурхайн бүтээгдэхүүний бирж бий болсон. Түүнчлэн тус хуралдаанаар "Монголын хөрөнгийн бирж" ХК-аас боловсруулсан Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд заасан 11 харилцааг зохицуулсан нэр бүхий таван журмыг мөрдүүлэх зөвшөөрлийг олгосноос гадна тус Хорооноос уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйлчилгээний хураамжийг биржээс ирүүлсэн санал, судалгааг харгалзан тогтоосон.

Хуулийн хэрэгжилт эхлэх хүртэлх хугацаанд "Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам"-ын дагуу нүүрсний цахим арилжааг "Монголын хөрөнгийн бирж" ХК-аар дамжуулан нээлттэй арилжаалсан бөгөөд 2023 оны 1 дүгээр сараас 2023 оны

6 дугаар сарын 29-ний өдрийг хүртэлх хугацаанд 54 удаа арилжаа зохион байгуулж, нийт 3.11 сая тонн нүүрсийг 1.3 их наяд төгрөгөөр арилжаалсан байна.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэллээ.

ҮНЭТ ЦААСНЫ ГАЗАР

---o-0-o---